

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Нанжидмаа
Утас: 70453799, Цахим хаяг: nanjidmaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15



ЗАВХАН СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Х.ЦЭНДЖАВ ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/135/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

0200200238

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,909,711.00	18,334,711.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,909,711.00	18,334,711.00
35400	Хангамжийн материал	17,909,711.00	18,334,711.00
35410	Бичиг хэргийн материал	454,530.00	402,530.00
35420	Аж ахуйн материал	5,200,900.00	5,755,900.00
35470	Бусад хангамжийн материал	12,254,281.00	12,176,281.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	754,775,834.35	727,177,446.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	754,775,834.35	727,177,446.67
39200	Биет хөрөнгө	751,795,834.35	724,197,446.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	718,667,878.00	718,667,878.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,335,247.84	-60,290,843.76
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	31,744,800.00	31,744,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,761,424.17	-26,649,030.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,691,560.67	22,192,016.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,652,227.11	-17,426,201.49
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	18,753,000.00	18,753,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,239,500.00	29,239,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,119,500.20	-6,601,166.88
39217	Ном	14,567,495.00	14,567,495.00
39300	Биет бус хөрөнгө	2,980,000.00	2,980,000.00
39301	Программ хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,980,000.00	2,980,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	772,685,545.35	745,512,157.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	772,685,545.35	745,512,157.67
51	Засгийн газрын хувь оролцоо	772,685,545.35	745,512,157.67
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	207,568,992.72	207,568,992.72
51200	Хуримтлагдсан үр дүн	280,987,184.95	253,823,505.27
51210	Өмнөх үеийн үр дүн	280,987,184.95	280,996,892.95
51220	Тайлант үеийн үр дүн		-27,173,387.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	284,129,367.68	284,119,659.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	772,685,545.35	745,512,157.67

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	89,703,832.00	90,121,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,600,132.00	
120	Нийтлэг татварын бус орлого	1,600,132.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,600,132.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,100,132.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	88,103,700.00	90,121,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	88,103,700.00	90,121,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	88,103,700.00	90,121,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	117,402,045.02	117,295,287.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,402,045.02	117,295,287.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,661,685.58	114,436,192.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,571,170.00	54,219,637.00
210101	Үндсэн цалин	49,448,487.00	50,019,637.00
210105	Гэрээтийн цалин	2,122,683.00	4,200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,586,385.70	7,267,443.00
210201	Тэтгэврийн даатгал	4,577,780.15	5,094,767.76
210202	Тэтгэмжийн даатгал	560,715.00	568,369.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	422,647.00	427,816.99
210204	Ажилгүйдлийн даатгал	99,234.00	106,954.32
210205	Эрүүл мэндийн даатгал	926,009.55	1,069,534.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,168,862.86	22,342,825.00
210301	Гэрэл, цахилгаан	255,362.86	113,825.00
210302	Түлш, халаалт	19,913,500.00	22,229,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,354,160.00	1,107,900.00
210401	Бичиг хэрэг	249,140.00	204,100.00
210402	Тээвэр, шатахуун	503,100.00	337,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00	200,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,571,920.00	365,800.00
2105	Норматив зардал	620,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	620,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	825,000.00	548,000.00
210601	Багаж хэрэгсэл	225,000.00	83,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	100,000.00	83,300.00
210604	Урсгал засвар	500,000.00	381,000.00
2107	Томилолт, зочны зардал	138,000.00	112,000.00
210702	Дотоод албан томилолт	138,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	779,900.00	1,240,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	689,900.00	1,024,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	90,000.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,618,207.02	27,598,387.68
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,618,207.02	27,598,387.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,740,359.44	2,859,095.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,440,359.44	2,609,095.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-27,698,213.02	-27,173,387.68
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-27,698,213.02	-27,173,387.68

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	88,603,700.00	90,121,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	88,103,700.00	90,121,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,103,700.00	90,121,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,103,700.00	90,121,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	88,603,700.00	90,121,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,603,700.00	90,121,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,863,340.56	87,262,805.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,000,615.58	54,219,637.00
210101	Үндсэн цалин	49,960,615.58	49,179,637.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,634,722.12	7,267,443.00
210201	Тэтгэврийн даатгал	4,563,016.57	5,094,767.76
210202	Тэтгэмжийн даатгал	533,141.00	568,369.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	429,148.00	427,816.99
210204	Ажилгүйдлийн даатгал	100,859.00	106,954.32
210205	Эрүүл мэндийн даатгал	1,008,557.55	1,069,534.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,168,862.86	22,342,825.00
210301	Гэрэл, цахилгаан	255,362.86	113,825.00
210302	Түлш, халаалт	19,913,500.00	22,229,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,311,240.00	932,900.00
210401	Бичиг хэрэг	244,140.00	204,100.00
210402	Тээвэр, шатахуун	503,100.00	337,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00	200,200.00
210404	Ном, хэвлэл	59,000.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,000.00	145,800.00
2105	Норматив зардал	500,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	830,000.00	548,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	83,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	83,300.00
210604	Урсгал засвар	500,000.00	381,000.00
2107	Томилолт, зочны зардал	138,000.00	112,000.00
210702	Дотоод албан томилолт	138,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,279,900.00	1,740,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,189,900.00	1,524,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,740,359.44	2,859,095.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,440,359.44	2,609,095.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,440,359.44	2,609,095.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.0	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	207,568,992.72	284,129,367.68	308,396,426.0	800,383,758.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,698,213.03	-27,698,213.03
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	207,568,992.72	284,129,367.68	280,987,184.95	772,685,545.35
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	207,568,992.72	284,129,367.68	280,987,184.95	772,685,545.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			9,708.00	9,708.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,568,992.72	284,129,367.68	280,987,184.95	772,685,545.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-9,708.00	0.00	-9,708.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			-27,173,387.68	-27,173,387.68
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	207,568,992.72	284,129,367.68	253,823,505.27	745,512,157.67

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,121,900.00	87,512,805.00	2,609,095.00	97.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,121,900.00	87,512,805.00	2,609,095.00	97.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,871,900.00	87,262,805.00	2,609,095.00	97.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,422,300.00	54,219,637.00	1,202,663.00	97.8%
210101	Үндсэн цалин	50,382,300.00	49,179,637.00	1,202,663.00	97.6%
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00		100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,482,000.00	7,267,443.00	214,557.00	97.1%
210201	Тэтгэврийн даатгал	5,265,100.00	5,094,767.76	170,332.24	96.8%
210202	Тэтгэмжийн даатгал	554,200.00	568,369.31	-14,169.31	102.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	443,400.00	427,816.99	15,583.01	96.5%
210204	Ажилгүйдлийн даатгал	110,900.00	106,954.32	3,945.68	96.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,108,400.00	1,069,534.62	38,865.38	96.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,508,200.00	22,342,825.00	1,165,375.00	95.0%
210301	Гэрэл, цахилгаан	1,279,200.00	113,825.00	1,165,375.00	8.9%
210302	Түлш, халаалт	22,229,000.00	22,229,000.00		100%
2104	Хангамж, бараа материалын зардал	937,900.00	932,900.00	5,000.00	99.5%
210401	Бичиг хэрэг	204,100.00	204,100.00		100.0%
210402	Тээвэр, шатахуун	337,800.00	337,800.00		100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	200,200.00		100.0%
210404	Ном хэвлэл	50,000.00	45,000.00	5,000.00	90.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	145,800.00		100.0%
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00		100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00		100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	548,000.00	548,000.00		100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	83,700.00		100.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	83,300.00		100.0%

**Завхан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

21060 4	Урсгал засвар	381,000.00	381,000.00		100.0 %
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	112,000.00	21,500.00	83.9%
21070 2	Дотоод албан томилолт	133,500.00	112,000.00	21,500.00	83.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,000.00	1,740,000.00		100.0 %
21080 1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,524,000.00	1,524,000.00		100.0 %
21080 2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00		100.0 %
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,000.00	250,000.00		100.0 %
21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	250,000.00		100.0 %
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	90,121,900.00	84,681,540.56	5,440,359.44	94.0%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
31000 1	Улсын төсвөөс санхүүжих				
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	90,121,900.00	84,681,540.56	5,440,359.44	94.0%
	Орон нутгийн төсвөөс	90,121,900.00	84,681,540.56	5,440,359.44	94.0%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байн

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан сумын Соёлын төв нь “Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж, түгээн дэлгэрүүлж бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж, авьяас билгийг нээн хөгжүүлнэ. Орон нутгийн болон аймаг бүсийн хэмжээнд соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж Соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж, өвлүүлэн үлдээхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,174.0 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 117,295.3 төгрөгийн 1 хувь буюу 1,172.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 938.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Завхан сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,173.3 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	17,909.7	18,334.7	425.0
Үндсэн хөрөнгө	754,775.8	727,177.4	-27,598.4
Нийт хөрөнгө	754,775.8	727,177.4	-27,598.4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	772,685.5	745,512.1	-27,173.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	772,685.5	745,512.1	-27,173.4

Бараа материалын дансны үлдэгдэл 18,334.7 мянган төгрөг болж 425.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,014.7 мянган төгрөгийн бараа материал худалдан бэлтгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 727,177.4 мянган төгрөг болж -27,598.4 мянган төгрөгөөр буурсан нь 7,499.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 418.0 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 106.7 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Завхан сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 119,111.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 119,111.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 28,989.1 мянган төгрөгөөр бууруулж 90,121.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх төсвийн гүйцэтгэлд тулгуурлаж баталдагтай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 90,121.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 90,121.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 90,121.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 90,121.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 87,262.8 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 2,609.0 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 87,262.8 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Завхан сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцроож 1 мэдээллийг байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Завхан сумын Соёлын төв	0	0	0	0	0	0	0	0	0	0


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/
АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /А.НАНЖИДМАА/

2022 оны 02 сарын 24-ний өдөр